



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/242

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 265 дугаар шийтгэх тогтоол, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 3/10144 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний их эмч Цэрэнгийн Ариунжаргалын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх эрхийг нэг жилийн хугацаагаар хасах тухай шийтгэх тогтоол 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон байх тул Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/201 дүгээр тушаалаар Ц.Ариунжаргалд олгосон ИЭ0026881 сери, 0026881 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Ц.Ариунжаргалын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай:

2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар хүчингүй болгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүйд тооцсон хугацаанд буюу 2021 оны 05 дугаар сарын 02-ны өдөр хүртэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бүртгэж, оруулахгүй байх;

2.3 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Б.Баясгалантай/, Нийслэлийн эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг /Д.Галсанцэдэн/, Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /Р.Энхтайван/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

141200840